



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 13 өдөр

Дугаар А/334

Хэрлэн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээг
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 66.3, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх хэсэг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь

1.Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Бавуугийн Адил (СЮ56042102)-ын эзэмшлийн Хэрлэн сумын 5 дугаар (Өндөрхаан), Тариаланчид гудамж байршилтай худалдаа үйлчилгээний зориулалттай 5772 м² газрыг иргэн Данистайн Жимсээ (СЮ74102809)-д 44 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2.Иргэн Данистайн Жимсээгийн эзэмшил газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3.Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Сүнгээ)-д үүрэг болгосугай.

4.Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн Данистайн Жимсээд үүрэг болгосугай.

5.Энэхүү захирамжийг гарсантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2014 оны А/384 дүгээр захирамжийн хавсралтын 10 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ